



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/93/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Отгонбаяр Утас: 89306788 Цахим хаяг: Otgonbayard@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
Асуудлыг онцолсон хэсэг	5
Аудитын гол асуудал	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/165
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА М.БАТЦОГТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны тээвэр шатахуун зардал өмнөх оноос 46.4 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь сумын бүх нутагт малын халдварт шүлхий өвчин гарсантай холбоотой шатах тослох материал худалдаж авснаас шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Тус сумын Засаг даргын Тамгын газрын жилийн төсвийн 64.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал болон ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 8 зорилт 94 арга хэмжээг төлөвлөж 86.7 хувь хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,276,178.00	16,533,178.00
33	АВЛАГА	105,000.00	1,935,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	105,000.00	1,935,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,171,178.00	14,598,178.00
354	Хангамжийн материал	8,671,178.00	11,098,178.00
35410	Бичиг хэргийн материал	197,178.00	197,178.00
35420	Аж ахуйн материал	4,064,000.00	5,006,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,980,000.00	3,465,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,430,000.00	2,430,000.00
35600	Мал амьтад	3,500,000.00	3,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,419,214,939.10	1,410,264,092.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,419,214,939.10	1,410,264,092.36
392	Биет хөрөнгө	1,335,979,820.60	1,327,418,973.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,144,591,598.01	1,173,491,598.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-141,383,420.55	-184,611,735.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	316,034,800.00	364,855,768.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-226,191,054.50	-247,496,975.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,575,602.00	124,922,230.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113,730,746.40	-65,279,157.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,324,973.33	19,283,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,995,372.91	-7,808,415.07
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,000,000.00	15,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	276,935,795.00	216,095,795.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-118,182,353.38	-81,033,133.43
393	Биет бус хөрөнгө	83,235,118.50	82,845,118.50
39301	Программ хангамж	2,132,000.00	2,132,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,142,000.06	-1,532,000.06
39303	Бусад биет бус хөрөнгө	82,245,118.56	82,245,118.56
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,431,491,117.10	1,426,797,270.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,431,491,117.10	1,426,797,270.36
51	Засгийн газрын хувь оролцоо	1,431,491,117.10	1,426,797,270.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	582,884,805.97	582,884,805.97
51101	Өмч: - төрийн	582,884,805.97	582,884,805.97
512	Хуримтлагдсан үр дүн	353,805,834.97	349,435,988.23
51210	Өмнөх үеийн үр дүн	353,805,834.97	354,129,834.97
51220	Тайлант үеийн үр дүн		-4,693,846.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	494,800,476.16	494,476,476.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,431,491,117.10	1,426,797,270.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	587,068,225.00	611,381,484.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,522,758.00	112,519,896.00

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

120	Нийтлэг татварын бус орлого	151,522,758.00	112,519,896.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	151,522,758.00	112,519,896.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	151,522,758.00	112,519,896.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	435,545,467.00	498,861,588.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,077,167.00	13,121,688.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,287,217.00	4,010,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,289,950.00	9,110,888.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	424,468,300.00	485,739,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	424,468,300.00	485,739,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	563,990,321.22	616,075,330.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	563,990,321.22	616,075,330.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561,863,899.22	577,876,419.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,030,000.00	270,345,926.95
210101	Үндсэн цалин	187,200,000.00	217,707,938.02
210102	Нэмэгдэл	40,630,000.00	52,637,988.93
210105	Гэрээт ажлын хөлс	25,200,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,159,100.00	33,242,300.00
210201	Тэтгэврийн даатгал	24,037,900.00	22,604,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,530,300.00	2,659,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,024,200.00	2,127,499.41
210204	Ажилгүйдлийн даатгал	506,100.00	708,566.59
210205	Эрүүл мэндийн даатгал	5,060,600.00	5,142,034.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,920,000.00	23,733,190.33
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,448,190.33
210302	Түлш, халаалт	16,920,000.00	18,785,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,280,180.00	59,331,208.00
210401	Бичиг хэрэг	4,641,180.00	5,972,808.00
210402	Тээвэр, шатахуун	27,323,100.00	40,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,489,000.00
210404	Ном, хэвлэл	799,600.00	799,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,496,350.00	1,869,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, эхуйн эд зүйлс	9,019,950.00	7,200,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,761,000.00	5,600,000.00
210604	Урсгал засвар	18,761,000.00	5,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,600,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,600,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,330,465.00	22,459,151.00

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЭДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,003,517.00	20,991,570.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	329,286.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,714.00	186,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,948.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	75,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	593,000.00
210807	Газрын төлбөр	800,000.00	408,381.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,283,154.22	160,164,642.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,636,830.00	31,093,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хс рогдол	136,146,324.22	127,570,742.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,126,422.00	38,198,911.72
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	23,857,166.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,052,166.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,805,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	126,422.00	14,341,745.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,422.00	14,341,745.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,077,903.78	-4,693,846.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	23,077,903.78	-4,693,846.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	435,545,467.00	498,861,588.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	435,545,467.00	498,861,588.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,077,167.00	13,121,688.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,287,217.00	4,010,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,289,950.00	9,110,888.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	424,468,300.00	485,739,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	424,468,300.00	485,739,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	432,135,867.00	492,761,588.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	432,135,867.00	492,761,588.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,009,445.00	452,627,676.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,030,000.00	270,345,926.95
210101	Үндсэн цалин	187,200,000.00	217,707,938.02
210102	Нэмэгдэл	40,630,000.00	52,637,988.93
210105	Гэрээт ажлын хөлс	25,200,000.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,159,100.00	33,242,300.00
210201	Тэтгэврийн даатгал	24,037,900.00	22,604,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,530,300.00	2,659,400.00

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,024,200.00	2,127,499.41
210204	Ажилгүйдлийн даатгал	506,100.00	708,566.59
210205	Эрүүл мэндийн даатгал	5,060,600.00	5,142,034.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,500,000.00	25,218,190.33
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,448,190.33
210302	Түлш, халаалт	14,500,000.00	20,270,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,380,680.00	59,226,208.00
210401	Бичиг хэрэг	4,741,680.00	5,867,808.00
210402	Тээвэр, шатахуун	27,323,100.00	40,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,489,000.00
210404	Ном, хэвлэл	799,600.00	799,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,496,350.00	1,869,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,019,950.00	7,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,861,000.00	5,600,000.00
210604	Урсгал засвар	19,861,000.00	5,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,600,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,600,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,330,465.00	22,459,151.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,003,517.00	20,991,570.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	329,286.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,714.00	186,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,948.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	593,000.00
210807	Газрын төлбөр	800,000.00	408,381.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,648,200.00	33,535,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,148,200.00	32,035,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,126,422.00	40,133,911.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	23,857,166.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,052,166.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,805,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	126,422.00	16,276,745.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,422.00	16,276,745.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,409,600.00	6,100,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,409,600.00	6,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,409,600.00	6,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,409,600.00	6,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,409,600.00	6,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,409,600.00	-6,100,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,884,805.97	494,800,476.16	353,805,834.97	1,431,491,117.10
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,884,805.97	494,800,476.16	353,805,834.97	1,431,491,117.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	324,000.00	324,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	582,884,805.97	494,800,476.16	354,129,834.97	1,431,815,117.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-324,000.00	00.00	-324,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,693,846.74	-4,693,846.74
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	582,884,805.97	494,476,476.16	349,435,988.23	1,426,797,270.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	485,739,900.0	471,398,154.3	14,341,745.7	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	485,739,900.0	471,398,154.3	14,341,745.7	97.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,502,100.0	447,540,988.3	7,961,111.7	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,407,100.0	270,345,927.0	4,061,173.1	98.5
210101	Үндсэн цалин	220,104,600.0	217,707,938.0	2,396,662.0	98.9

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	64,302,500.0	52,637,988.9	1,664,511.1	96.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,242,300.0	33,242,300.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	22,604,800.0	22,604,800.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,659,400.0	2,659,400.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,127,500.0	2,127,499.4	00.6	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	531,800.0	708,566.6	-176,766.6	133.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,318,800.0	5,142,034.0	176,766.0	96.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,500,000.0	21,210,160.3	289,839.7	98.7
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.0	3,710,160.3	289,839.7	92.8
210302	Түлш, халаалт	17,000,000.0	17,000,000.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	500,000.0	500,000.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	68,000,000.0	57,858,350.0	141,650.0	99.8
210401	Бичиг хэрэг	4,500,000.0	4,499,950.0	50.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	40,000,000.0	40,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500,000.0	3,489,000.0	11,000.0	99.7
210404	Ном, хэвлэл	800,000.0	799,900.0	100.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,869,500.0	130,500.0	93.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,000.0	7,200,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.0	11,700,000.0	300,000.0	97.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,100,000.0	4,800,000.0	300,000.0	94.1
210604	Урсгал засвар	6,900,000.0	6,900,000.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.0	3,000,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	3,000,000.0	3,000,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,549,000.0	16,648,351.0	2,900,649.0	85.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,219,000.0	15,180,770.0	2,038,230.0	88.2
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	186,200.0	13,800.0	93.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.0	200,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.0	80,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.0	593,000.0	57,000.0	91.2
210807	Газрын төлбөр	1,200,000.0	408,381.0	791,619.0	34.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,803,700.0	33,535,900.0	267,800.0	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,303,700.0	32,035,900.0	267,800.0	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.0	1,500,000.0	00.0	00.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,237,800.0	23,857,166.0	6,380,634.0	78.9

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	30,237,800.0	23,857,166.0	6,380,634.0	78.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,390,600.0	22,052,166.0	6,338,434.0	-22.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,847,200.0	1,805,000.0	42,200.0	97.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	485,739,900.0	471,398,154.3	14,341,745.7	97.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	485,739,900.0	471,398,154.3	14,341,745.7	97.0
132001	Орон нутгийн төсвөөс	485,739,900.0	471,398,154.3	14,341,745.7	97.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	/Төгрөгөөр/	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,121,688.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,121,688.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,121,688.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,008,030.00
210301	Гэрэл, цахилгаан	738,030.00
210302	Түлш, халаалт	3,270,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00
210304	Байрны түрээс	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,367,858.00
210401	Бичиг хэрэг	1,367,858.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,810,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,810,800.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,935,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,121,688.00
131311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,121,688.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,010,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,175,888.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий орон нутгийн төсвийн байгууллага юм.

Улаан-Уул сумын ЗДТГ нь тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Санхүүгийн үндсэн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж, үр дүнтэй төсвийн төлөвлөлт хийнэ.
2. Нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
3. Захиргааны үйлчилгээг чанартай хүргэнэ.
4. Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.
5. Бүтээн байгуулалт, бүтээлч ажлыг зохион байгуулан шинэ санаачилгыг дэмжин ажиллана.
6. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хуулийн хүрээнд хангана.

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 8 зорилт 94 арга хэмжээг төлөвлөж 86.7 хувь хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагааг явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант онд байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Улаан-Уул сумын ЗДТГ-ын даргын тушаалаар 3 орон тоотой дотоод хяналтын баг томилон ажиллуулж байгаа ба 2022 онд аймгийн Санхүү хяналт аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,693.8 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	105,0	1935,0	1830,0
Бараа материал	12,171.2	14598,2	2,427,0
Үндсэн хөрөнгө	1,419,214,9	1410264,1	-8950,8
Нийт хөрөнгө	1,431,491.1	1,426,797.3	-4693.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	582,884.8	582,884.8	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,431,491.1	1,426,797.3	-4,693.8

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал данс өмнөх оноос өссөн, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх хүснэгтээс харахад мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө данс өмнөх оноос өсөж, бараа материал, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Авлага данс 1,935.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн орлого төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
2. Бараа материал дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,427.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 942.0 мянган төгрөг, түлш шатах тослох материал 1,485.0 мянган төгрөгөөр нэмж худалдан авсантай холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 8,950.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн зардалтай холбоотой байна. Хөрөнгө, эх үүсвэрийн дансны өөрчлөлт нь авлага, бараа материалын дансны эцсийн үлдэгдэл өсөлт, тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл өссөн, тайлант үеийн үр дүн буурсан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй ажилласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 482,600.0 мянган төгрөг, нийт зарлагыг 482,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын төсвийг сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 02 тоот тогтоолоор 448,446.0 мянган төгрөгөөр баталж, 2022 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот тогтоолоор 37,293.9 мянган төгрөгөөр нэмэх тодотгол хийж, 485,739.9 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 37,293.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 485,739.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 485,739.9 мянган төгрөг буюу 97 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний тэлэвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101-үндсэн үйл ажиллагааны зардал	306,607,2	302,502,1	4,105,1	98,6%
2	80106-баг хоргоны Үндсэн үйл ажиллагааны зардал	52,279,3	51,568,3	711,0	98,6%
3	80112-нийтлэг үйлчилгээ	49,592,9	48,754,0	838,9	98,3%

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

4	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80305-биеийн тамирын, уралдаан тэмцээн	2.000,0	1,880,0	120,0	94%
5		80802-ажил олгогчоос олгох тэтгэмж	1,847,2	1,805,0	42,2	97,7%
6		80815-сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	28,390,6	22,052,2	6,338,4	77,7
7		81102-орон нутгийн нөөц хөрөнгө	19,803,7	19,655,9	147,8	99,2%
8		82801-улсын их баяр наадам	8.000,0	8,000,0		100%
9		71413-Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх	81701-Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	17.219,0	15,180,8	2,038,2
Нийт дүн			485.739,9	471,398,2	14,341,7	97%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 13,121.7 мянган төгрөг хүлээн авсан байна. Үүнд:

- Статистикийн хэлтсээс эхний хагас жилийн мал тооллогын зардал 4,010.8 мянган төгрөг,
- Сумын төвийн автомат худгийн орлого 7,175.9 мянган төгрөг
- Аймгийн усны сав газрын усны санхүүжилт 1,935.0 мянган төгрөг

Нэмэлт төсвийн данснаас 11,186.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 424,468.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,367.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Засаг Даргын Тамгын газар 2022 онд цалингийн зардалд 4,061.2 мянган төгрөг, Эд хогшлын зардал 300.0 мянган төгрөг, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрээс 3260.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 72.0 мянган төгрөг, Бараа ажил үйлчилгээний бусад зардал 267.8 мянган төгрөг, Бусад урсгал шилжүүлгийн зардал 6,380.6 мянган төгрөгийг тус тус хэмнэж, үндсэн үйл ажиллагааны зардал 14,341.7 мянган төгрөгийг төвлөрүүлж ажилласан. Мөн нэмэлт дансны санхүүжилт оны сүүлд гүйлгээ хаагдах үед 1,935.0 мянган төгрөгийн орлого орж ирсэн нийт 16,276.7 мянган төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлд хяналт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 481,303.3 мянган төгрөгийн 17 гүйлгээнээс 188,814.2 мянган төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 54,052.1 мянган төгрөгийн 5 гүйлгээнээс 15,500.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Иймд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго баримталсан байна.

1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалттай нийцсэн ба, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 75,395,800.00 (далан таван сая гурван зуун ерэн таван мянга найман зуун) төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй, 128,918,400.00 (нэг зуун хорин таван сая есөн зуун арван найман мянга дөрвөн зуун) төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 189,900.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 3,600.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	1	189,900.0	1	189,900.0	

Зөвлөмж	1	3,600.0	1	3,600.0	100
Нийт дүн	2	193,500.0	2	193,500.0	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч онцгойлох асуудал гараагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 204,249.2 мянган төгрөгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрсэн тул 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Залруулсан алдаа.

Нэмэлт санхүүжилтийн орлого 1935.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, авлага үүсгэхдээ үр дүнгийн тайлан, тохируулгын тайланд 1,935.0 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг тус тус залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлд хяналт хийхэд нийт 204,249,200.0 төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 75,395,800.00 (далан таван сая гурван зуун ерэн таван мянга найман зуун) төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй, 128,918,400.00 (нэг зуун хорин таван сая есөн зуун арван найман мянга дөрвөн зуун) төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: ...6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн багламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.1 Зөвлөмж

Аудитаар хугацаатай зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	дүн		
Шилэн дансны тухай хууль зөрчсөн	1	204,249.2	-	-	1	204,249.2	-	-
Дүн	1	204,249.2	-	-	1	204,249.2	-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Д.ОТГОНБАЯР ОГНОО: